

ЛГБТК: ХҮЙСИЙН БОЛОН БЭЛГИЙН ЧИГ БАРИМЖААНЫ АСУУДАЛ ФИЛОСОФИ, ЁС ЗҮЙН ЭРГЭЦҮҮЛЭЛД ХҮРГЭХ НЬ

Б.Мөнхжавхлан, доктор (Ph.D)
Профессор Б.Дагзмаа, доктор (Ph.D)
МУИС, Философи шаашин судлалын тэнхим

Түлхүүр үг: ЛГБТК хүмүүс, хүйс, бэлгийн чиг баримжаа, хомосекс, хүний эрх, күйир онол

Нийгэм өөрчлөгдөж, үзэл санаа нээлттэй болохын хэрээр хувь хүний оршихуй, амьдрахуйн олон асуудал нүднээ илт, бас анхаарлын төвд орох болсон юм. Үүний нэг илрэл нь ёс зүйн хувьд чухал, тулгамдсан нэгэн сэдэв болох ЛГБТК¹ хүмүүс, тэдний хүйсийн болон бэлгийн чиг баримжааны² онцлог, улмаар тэдгээр хүмүүсийн нийгмийн харилцаанд оролцож буй байдал, нийгмийн статусын тухай болно.

Энэ бол дан ганц философи, түүний нэг бүрэлдэхүүн болох ёс зүйн сэдэв төдийгүй гадна анагаах ухаан, улс төр, хүний эрх, сэтгэл судлал зэрэг олон талбарт авч үздэг өргөн хүрээтэй асуудал юм. Дэлхийн зарим улс оронд ЛГБТК иргэдийг бусдаас өөр хэмээн ялгаварлан хандах үзэгдэл байсаар байгаа нь хүний эрх, философийн үүднээс тэдний асуудлыг авч үзэх шалтгаан болж байдаг.

ЛГБТК хүмүүсийн бэлгийн чиг баримжааны тухай асуудлыг сүүлийн хэдэн арван жилд нийгэмд тусгайлан ярьж буй боловч шинэ бус, өмнө нь энэ талаар авч

үзэж байсан түүх цөөнгүй бий. Тусгайлан ярих гэдгийн цаана, ЛГБТК хүмүүсийг олонхиос ялгаатай, маргинал байдлаар нийгмийн харилцаанд тэр ч атугай гэр бүлийн харилцаанд³ (Иргэний нийгмийн хууль эрх зүй, нийгмийн орчны оролцоонд суурилсан үнэлгээ, шинжилгээ. НҮБ, 2014, хууд. 34) ялгаатай авч үздэг тул ийн хэлж байна. Тухайлбал “америкийн гей болон лесбичүүд яагаад хууль ёсны гэрлэлтийн эрхтэй болохыг хүсэж байсныг ойлгоход тийм хүнд биш. Сэтгэл санаа, оюун бодол, ёс суртахууны ач холбогдлоос гадна одоо хэр нь хомосекс хосуудад олддоггүй хуулийн болон эдийн засгийн ач холбогдолтой байлаа. ...хүүхдээ харсны хөлс, гэр бүлийн өмчлөл, нийгмээс гэр бүлд үзүүлэх хөнгөлөлт, татварын хөнгөлөлт, шүүхэд гэр бүлээ төлөөлөх зэрэг гэрлэлтээр олох эрхүүд лесби болон гей хосод хэзээ ч олддоггүй (Вольф, 2021, хууд. 230)” гэсэн нь эдгээр ЛГБТК хүмүүсийн хувьд ийнхүү боломжоос ангид, маргинал байдгийг харуулж байгаа юм.

1 ЛГБТ: лесбиян, гей, бисексуал, трансжендэр гэсэн үгсийн товчлол. ЛГБТ хэмээх үг нь бэлгийн цөөнхийг бүрэн төлөөлөх утгаараа зөв хэрэглээ болдог. ЛГБТ хэмээх товчлолыг хэрэглэхдээ хүмүүсийг төөрөлдүүлэхгүйн тулд заавал бүрэлдэхүүн үгсийг тайлбарлах нь зүйтэй. Сүүлд ЛГБТИ гэх болсон. Энд интерсекс гэдэг ойлголт нэмэгджээ. Бэлгийн цөөнхийг нэрлэсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр томъёо, товчлол болно. Сүүлийн үед мөн күйир гэдэг нэршлийг хэрэглэж байна.

2 **Бэлгийн чиг баримжааны илэрхийлэл:** Бэлгийн дур сонирхлын хувьд хэнд татагдаж байна вэ? гэдэг мэдрэмж дээр үндэслэн хүн өөрийгөө хэн болохыг тодорхойлоход оршино. Эсрэг хүйсийн, ижил хүйсийн, эсвэл аль аль хүйсийн хүнд татагддаг байж болно.

3 Монголын ЛГБТ хүмүүсийн гэр бүлийн гишүүдийн олонхи нь тэдний талаар сөрөг хэвмэл ойлголттой байдаг тул ЛГБТ хүмүүсийн олонхи нь мэдэгдэхгүй байхаар шийддэг байна. ЛГБТ олон нийтийн дунд явуулсан судалгаанд оролцогчдын 86.7 хувь нь “Та гэр бүлийнхэндээ ялгаварлан гадуурхагдаж байсан уу?” гэсэн асуултанд тэгнэ гэхээс эмээгээд гэр бүлийнхэндээ мэдэгдээгүй гэж харуулсан байна (ХЭҮК, 2013). Азид ЛГБТ байх нь: Монгол улсын тайлан. Лесбиян, Гей, Бисексуаль, трансжендер хүмүүс (ЛГБТ)

Дэлхийн бүх улс үндэстэнд ижил хүйстний харилцаа ил болон далд хэлбэрээр оршин байдаг. Учир нь зарим улс орнууд ийм харилцааг хэвийн бус, хууль бус хэмээн үзэж тэдэнд ял шийтгэл оногдуулж, цаазаар авах явдал саяхныг хүртэл байжээ⁴. “Ижил хүйстний харилцаа (хомосексуализм) хэмээх ухагдахуун нь өнгөрсөн зууны 60-аад онд нэр томъёоны эргэлтэд орж үүнээс хойш, тэд нарт бэлгийн харилцааны өвөрмөц гажилттай хүмүүсийн тусгай бүлэгт оруулж иржээ. Эмэгтэй ижил хүйстний харилцаа гэдэг ухагдахуун нь бүр хожим гарчээ” (Гидденс, 2006, хууд. 151). Судлаач Дэмир Бэнович эл асуудлыг эрх чөлөө, бие даасан байдлын хувьд дараахь 5 хүрээнд онцолж үзсэн байна. Ийнхүү (1) хүний бэлгийн харилцааны мөн чанар (2) түүний төрөлхийн үйл ажиллагаа ба зорилго; (3) хетеросексуализм ба бинар үүргийн түүхэн парадигм; (4) ёс суртахууны асуудал; (5) ижил хүйстнүүдийн хоорондох хайр дурлал, нөхөрлөл, гэрлэлтийг хууль ёсны гэж үзэх шалтгаануудыг авч үзэхийг тэрээр санал болгосон байдаг (Vanovic, 2020).

Энэхүү харилцаанд оролцдог хүмүүсийг бэлгийн чиг баримжаа ялгаатай хэмээн үзэж, улмаар сэтгэцийн өвчтэй гэж тодорхойлж байсан түүх бий. Анх Роберт Спицер энэ харилцаа нь ямар нэг сэтгэцийн өвчин биш гэж үзээд Америкийн сэтгэл судлалын холбоонд хандаж ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг клиникийн сэтгэцийн өвчний жагсаалтаас хасахыг уриалж байсан (A.Grisanti, 2008). Хүний

бэлгийн чиг баримжааг төрөлхийн ба олон талт мөн чанар хэмээн хүлээн зөвшөөрч Америкийн сэтгэц, эмгэг судлалын холбоо 1973 онд ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг сэтгэцийн өвчний ангиллаас албан ёсоор хасаж, үүний дараа 1974 онд Америкийн сэтгэл судлалын холбоо ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг хүний төрөлхийн буюу салгаж болшгүй мөн чанар хэмээн үзэж сэтгэцийн өвчин биш гэдгийг зарлажээ (П.Золжаргал, 2020). Олон улсын түвшинд 1990 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг хүний төрөлхийн ба салгаж болшгүй мөн чанар хэмээн хүлээн зөвшөөрч сэтгэцийн өвчнөөс албан ёсоор хассанаа мэдэгдсэн байна. Энэхүү бэлгийн чиг баримжааг сэтгэцийн эмгэг хэмээн үзэж байсан хандлага өөрчлөгдөхийн сацуу олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд бэлгийн чиг баримжаа ялгаатай хүнийг хамгаалах заалтууд орох болсон юм. НҮБ-ын Иргэний болон Улс төрийн олон улсын Пактын хэрэгжилтийг хянадаг Хүний эрхийн хорооноос 1994 онд анх удаа “хүйс” хэмээх ойлголтод хүйстэй холбоотой, хүний хайр дурлал болон бэлгийн амьдралын илэрхийлэл болсон бэлгийн чиг баримжаа гэдэг ухагдахуун багтана гэсэн байна.

Хүн төрөлхтний соёлын чухал хэсэг болох домог, туульсуудад хомосексийн⁵ тухай өгүүлэмжүүдийг олж харах боломжтой юм, тухайлбал эртний Грекийн болон Энэтхэгийн бурхадын талаарх домгуудад

4 Вашингтонд байрлалтай Пью Судалгааны төвийн 2020 оны мэдээллээс харахад сүүлийн 20 гаруй жилд хомосексийг олон оронд хүлээн зөвшөөрөх болсон байна. Улс орнууд бус нутаг, эдийн засгийн хөгжлийн хувьд үүнд ялгаатай хандаж байдаг аж. Зүүн Европ, Орос, Украин, Ойрхи Дорнод, Сахарын Африкийн орнуудаас илүүтэй Баруун Европ, Америкт бэлгийн чиг баримжааны ялгаатай байдалд нээлттэй хандсан байна. Энэтхэг, Өмнөд Солонгос, Өмнөд Африкт хүлээн зөвшөөрч буй хандлага эрчимтэй нэмэгдсэн. Өндөр хөгжилтэй, баян орнуудад, мөн боловсрол өндөр байх тусам, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү эл асуудлыг зөвшөөрөн хүлээн авдаг байдал ажиглагджээ.

<https://www.pewresearch.org/global/2020/06/25/global-divide-on-homosexuality-persists/>

5 Жич энд өгүүлэхэд ЛГБТ хэмээх нэр томъёог хэрэглэхийн сацуу хомосекс гэдэг ойлголтыг хэрэглэхийг зөвшөөрдөггүй талаар 2019 онд хэвлэгдсэн “Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн тухай хэрхэн бичих вэ?” Хэвлэл мэдээллийн ажилтнуудын гарын авлагад бичсэн байна. Хэдий тийм боловч энэ талаарх философи, ёс зүйн холбогдолтой эх сурвалжуудтай танилцах явцад тэдгээрт хомосекс, хомосексуализм гэсэн ойлголтыг хэрэглэсэн байх тул бид тухайн эх сурвалжийн дагуу эдгээр ойлголтыг өгүүлэлдээ хэрэглэж буй болно

ижил хүйсийн ойлголтод хамаарах жишээ олон бий.

Эртний грекийн философид гетеросексуаль, гомосексуаль гэсэн ойлголтууд байгаагүй ч хамааруулж болох баримтууд байсан ажээ. Платон, Аристотель нар эл асуудлын тухай хэлэлцэж байжээ. Орчин үед зарим судлаач, эртний грекийн философийг судлах явцдаа ижил хүйсийн бэлгийн харилцааг эерэг байдлаар авч үзсэн соёл тэр үед байжээ хэмээсэн байдаг. Жишээ нь Платоны “Симпозиум”-д эр хүйсийн бэлгийн харилцааг эр, эм хоорондын бэлгийн харилцаанаас илүү давуу гэж үзсэн байна. Эр, эм хүмүүсийн бэлгийн харилцаа бол дур хүслээ л хангах, мөн нөхөн үржихүйн зорилготой бол, эр хүйс хоорондын хайрын харилцаа бол сайн зан араншин, мэргэн ухааны зарчимд үндэслэсэн байдаг. Жозеф Шварцын үзснээр Платон нь бие махбодын хайраас илүүтэй бие махбодын бус хайрыг онцолсон (Schwartz, 2008) байдаг юм. Энэ нь Платоны санааны тухай онолтой холбоотой бөгөөд түүний үзэлд хайр бол бие махбодийн дур хүслээс дээгүүр ёс суртахуунлаг, сайн гэдэгт холбогдох зүйл ажээ. Түүний үзэл баримтлал хетеросекс харилцаанд түшиглэсэн нийгмийн сэтгэлгээнд шууд тохирохгүй ч тогтсон хандлагыг өөрөөр харахад нэмэр болох юм. Моррис Каплан тэмдэглэхдээ энэ текст ижил хүйстнийг эс зөвшөөрдөг бидний өөрсдийн түүхийн болон соёлын хязгаарлалт, ижил хүйсийн практикийн орчин үеийн онцгой, нийгмийн контекстийг ойлгоход тусална гэсэн. Орчин үеийн контекст гэдэг нь юу вэ хэмээвээс “хетеросексуаль” байдал бол зайлшгүй, харин ижил хүйсийн бэлгийн харилцаа бол этгээд гэсэн үг бөгөөд энэ үзэл санаа Христийн шашны үзлээр хэлбэржиж бий болсон аж. Энэ үзэлд бэлгийн харилцаа натурал шинжтэй, ёс суртахуунлаг бэлгийн харилцаа бол нөхөн үржихүйн зорилготой

байх ёстой гэж байв (Tuana & Laurie Shrage, 2005, p. 21).

Христийн шашинд бэлгийн чиг баримжаа, хомосексийн тухайд шашны сургаал, баримтлах дэг жаягт холбогдох асуудлаас гадна улс төр, нийгмийн нөхцлөөс үүдэж сөрөг хандаж байсан. Христийн шашинд зарим төрлийн сексийн хэлбэрийг нүгэл хэмээн үздэг байжээ. Жишээ нь Хуучин гэрээний Леви номын 18 (22-23), “эр хүн эмэгтэйтэй хавьтагч адил, чи эр хүйстэнтэй бүү хавьт. Энэ нь жигшүүрт зүйл юм. Мөн чи аливаа амьтантай хавьтаж, түүнтэй хамт бузарлагдаж болохгүй (Ариун Библи, 2013, хууд. 169)” гэсэн байдаг.

Дундад зууны патристикийн үед Гэгээн Августин гэрлэлтийн хүрээнд эр, эм хоёр үр удмаа үлдээхийн тулд бэлгийн харьцаанд орохыг зөвшөөрдөг бол бэлгийн харьцааны бусад хэлбэрийг нүгэлд тооцож байв. Ийнхүү байгалийн хуулийн үүднээс ижил хүйстний харилцаа зүй бус гэдэг хандлага барууны уламжлалд маш их нөлөөтэй болж иржээ. Тухайлбал “ижил хүйстэн” буюу хомосекс гэдэг ойлголтыг “содоми” буюу бэлгийн гаж буруу харилцаа гэсэн ойлголттой холбон тайлбарлах болсон нь үүний нэг баталгаа юм. Содоми бол хүний бэлгийн чиг баримжаанд гэхээс илүү үйлдэлд хамаатай ойлголт бөгөөд энэхүү ойлголтоор эрэгтэй ба эмэгтэй хүний хооронд, эрэгтэй хүн ба амьтны хооронд болон эрэгтэйчүүдийн хооронд тогтоосон бэлгийн харилцааг хамруулан авч үздэг байжээ (Гидденс, 2006, хууд. 151).

Энд нэг зүйлийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Өрнөдийн сонгодог философид хомосексийн тухай асуудлыг сөрөг өнцөгөөс авч үзэж, няцаахад гол үндэслэгээ болж байсан баримтлал бол байгалийн хуулийн тухай үзэл юм.⁶

6 Байгалийн хууль (Natural law) хүний авир үйлдлийг удирдан чиглүүлж байх объектив хэм хэмжээг илэрхийлэх бөгөөд үүнийг эртний Грек Ромын сэтгэлгээн дэх стоицизмд, дундад зууны үед Аквины Фома дэмжин баримталж байв. Хүн, Бурханы илчлэлтээр бус харин оюун ухаанаараа хэрхэн зөв амьдрах тухай авч үздэг бөгөөд хомосексийг тэд байгалийн бус зүйл хэмээсэн аж.

Байгалийн хуулийг дэмжин хамгаалсан хамгийн нөлөө бүхий үзэл баримтлалыг XIII зуунд Аквины Фома бий болгосон. Тэрбээр гэрлэх, үр удмаа үлдээх зэрэг хүний амьдралын зарим чухал асуудлыг авч үзэхдээ ижил хүйстнүүдийн бэлгийн харилцааны талаар онцлон бичдэггүй байсан хэдий ч хетеросексуаль харилцаанаас бусдыг нүгэл гэж үздэг нь илт байв. Харин гэрлэсэн хосууд хүүхэдтэй болох хүсэл эрмэлзлэлгүйгээр гагцхүү хайраа илэрхийлэх зорилготой бэлгийн харьцаанд орох нь хэвийн зүйл хэмээн тэрээр үзэж байв.

XVII-XVIII зуунаас эхлэн аливаа асуудалд теологиос илүүтэй шинжлэх ухааны үүднээс хандах байдал эрс нэмэгдсэн нь механик, анагаах ухаан, сэтгэл судлалын хөгжилтэй холбоотой байв. Механикийн хуулиудын үндсэн дээр байгалийн үзэгдлийг судлах болсон шинжлэх ухааны тэр дундаа анагаах ухааны нэр хүнд асар өссөн тухайн үеэс хүмүүс бэлгийн харилцааг төрөлх шинжтэй, биологийн нэг үзэгдэл гэх болсон. Энэхүү хандлага нь хомосексуал харилцааг өөрөөр авч үзэхэд нөлөөлсөн суурь нь болж өгсөн аж.

XIX-XX зууны зааг дээр гарч ирсэн психоаналитик сэтгэл судлалын үндэслэгч, философич Зигмунд Фройд⁷ (1856–1939), зарим хүн ижил хүйстэн болдог нь сэтгэлзүйн шалтгаанаар нөхцөлдөг бөгөөд ерөнхийдөө биологи шинж нь бэлгийн хөгжилд илүү шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг гэж үзээд сэтгэл зүй, биологийн харилцан үйлчлэлд илүү анхаарал хандуулж эхлэв. Фройд ижил хүйстэн байх нь эмгэг гэж шууд тодорхойлоогүй ч энэ нь бэлгийн бүрэн төлөвшилийг илэрхийлэхгүй гэж байжээ. Гэхдээ тэрээр ижил хүйстнүүдийг нийгэмд үр бүтээлтэй амьдрах чадвартайн сацуу, ижил хүйстэн байхыг хуулиар гэмт хэрэг гэж үзэхгүй (Glass, 2017) байхыг дэмжиж, энэ утгаараа хетеронормативизмын эсрэг байр

суурьтай (Lang, 2021) байсан юм. Тэрээр хомосекс бэлгийн харилцааг нийгмийн зан авирын “хурц илрэл” (Andreas De Block, 2007) гэж байжээ.

XX зуун гарсаар эл асуудлыг өөрөөр авч үзэх болсон. Эссенциализм, конструктивизмийн чиглэлүүд бэлгийн чиг баримжааны ойлголтыг ялгаатай тайлбарлах болов. Эссенциализм бол бэлгийн чиг баримжааны төрлүүд болох хетеросексуал, хомосексуал, бисексуал нь бусад соёлд болон түүхийн туршид байх “хүний жам ёсны төрлийг” (natural human kinds) төлөөлдөг (A.Yarhouse, 2004) гэсэн үзэл юм. Энэ үзэл баримтлалын дагуу ижил хүйстэн байх нь соёл, түүхэн бүтээгдэхүүн гэхээсээ илүү төрөлхийн, байгаллаг зүйл юм. Ийнхүү нийгмийн үнэлэмжүүд өөрчлөгдөх хирээр гэрлэлтээс өмнөх бэлгийн харилцаа хориотой зүйл байхаа больж тодорхой хугацаа өнгөрсний дараа хомосексуал хүмүүсийн харилцааг үгүйсгэх нь бас утгагүй болж эхэлсэн байна.

Мишель Фуко харин бэлгийн амьдрал бол цаг хугацааны явцад эрх мэдлийн харилцаанаас болж өөрчлөгддөг нийгмийн конструкц гэж үзсэн нь сонирхол татахуйц юм. Эрх мэдлийн шинэ техникүүд хүн амын өсөлтийг барихад буюу нийгмийн эрүүл мэнд, эрүүл ахуй, орон байрны нөхцөл, урт наслалт, төрөлт, бэлгийн мэдрэмжийн шинээр гарсан асуудлаас үүдэн удирдлага, хяналтыг нь хийхэд хэрэг болдог гэдгийг Фуко битүүгээр сануулдаг. Бэлгийн мэдрэмж бол биенийг сахилгажуулах, хүн амыг хянах уулзвар цэг дээр байрладаг учраас улс төрийн утгаар чухал ач холбогдолтой (Нийгэм-улс төрийн философийн орчин үеийн онолууд, 2003, хууд. 209). Тэрээр “бэлгийн мэдрэмж бол жам ёсны бодит байдал биш, харин хувь хүнийг хүчтэй хянах, тандах байдлыг бий болгодог дискурс практикийн цогц тогтолцооны бүтээгдэхүүн мөн” гэж үзжээ (Нийгэм-улс төрийн философийн орчин

7 1935 онд З.Фройд, ижил хүйстэн хүүгийн ээжид захидал бичсэн нь хожим ихэд алдаршсан гэдэг. “Америк ээжид бичсэн захидал”-аас түүний яагаад хомосексийг өвчин гэсэн ангилалд оруулахгүйг илэрхийлсэн байр суурийг мэдэж болно. <https://pep-web.org/browse/document/zbk.051.0423a?page=P0423>.

үеийн онолууд, 2003, хууд. 210). Түүний үзлээр ижил хүйстэн байна гэдэг нь төрөлх шинж биш, харин нийгэм, түүхийн үр дүнд бий болсон зүйл ажээ. Ийм үзлийг баримталдаг судлаачид ангийн харилцаа, хүмүүнлэгийн ухаан, түүхэн бүтэцчилэл бэлгийн категориудын ангилал, хувийн шинж чанарыг бий болгодог гэдэг. Бэлгийн туршлага, үзэл бодлын илэрхийллийг нийгмийн бүтээгдэхүүн гэсэн үзэл хандлага гарч ирснээр үүнийг нийгмийн конструктивизм гэж тэмдэглэж иржээ. Иймээс хомосекс бол тодорхой нэг бэлгийн чиг баримжааны бүтэц юм. Социаль конструктивистууд нийгмийн тодорхой бүтэц нь бэлгийн хэв маягийг бий болгодог гэж үздэг. Соёлоос үл хамаарах бэлгийн ямар ч хэв маяг байдаггүй; бэлгийн чиг баримжаа, үзэл баримтлал, туршлага хүртэл өөрөө түүхийн бүтээгдэхүүн аж. Өөр нэг чухал тайлбар бол ижил хүйсийн асуудлыг улс төрийн үүднээс авч үзэх явдал байсан нь соёлд бас хамаардаг. Сюзан К.Кан, хомосекс харилцааг тодорхой соёлд эрэгтэй “эрх мэдэл”-ийг (K.Cahn, 1992) илэрхийлдэг харин лесбиян байх нь эмэгтэй эрх мэдлийн илэрхийлэл болж байгаагүй талаар дурдсан байдаг.

Крайл, Стефенс нар ижил хүйсийн асуудалд генеалогийн талаас судалгаа хийж “нормал буюу хэвийн” гэдэг үгийн этимологи утгыг шинжилсэн, ингэхдээ энэ нь хэм хэмжээ заасан, тодорхой нэг болон нийтлэг соёлд хүлээн зөвшөөрсөн ойлголт бөгөөд тэрхүү “хэвийн” байдлаас өөр нь хэвийн бус, этгээд, ялгаатай гэсэн утга илэрхийлдэг болсныг судалсан. Ялангуяа эрүүл мэнд, сэтгэл судлалын шинжлэх ухаанд эмгэг гэдэг ойлголттой эсрэгцүүлснийг авч үзсэн байна. Тэднийхээр “хэвийн болон хэвийн бус байдал бол эсрэг тэсрэг зүйл биш, харин тодорхой бололцоонууд бүхий хүрээний хэсэг” ажээ (Peter Culye, 2017, p. 19). Энэ талаар Бауэр “хомосексуаль байдлыг хэвийн бус гэж үзээд, гетеросексуалийг хэвийн

гэж эсрэгцүүлж буй нь институтчилэлтэй холбоотой” (Bauer, 2006) гэсэн. Түүнийхээр эр, эм хоёрын сэтгэл хөдлөлийн болон бэлгийн харилцааг гэрлэлтээр холбон баталгаажуулж байгаа нь институтжүүлж буй хэрэг бөгөөд институтжинэ гэдэг нь хуульчлагдаж, ёс зүйн хувьд зөв, хууль ёсны, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөж байгааг илэрхийлнэ. “XX зуунаас бэлгийн чиг баримжааны асуудлыг шинжлэх ухааны үүднээс гэхээс илүүтэй нийгэм, улс төр, философийн үүднээс авч үзэх хандлага бий болсон нь энд холбогдоно. Мэтью Эндлерийн⁸ үзсэнээр бэлгийн буюу сексуаль (sexual identity) онцлог шинж бол нийгмийн онцлог шинж юм. Улмаар хетеронорматив идеологи нь ижил хүйстэн биш хүнийг “хэвийн”, “байгалийн” хэмээн хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэдэг. Лесбиян, гей, бисексуал хүмүүс хачирхалтай буюу “queer” гэж “гарч ирдэг” бол “хэвийн” хүмүүс “хэвийн” гэгдэж “гарч ирээд” байдаггүй... энэ бол “хэвийн” гэдэг онцлог шинжийг стандарт, өөрчлөгдөшгүй, универсал гэж илэрхийлдэг байдал... гэж үзсэн байна (Ander, Queer and Straight, 2022). Тэрбээр, сексуаль онцлог шинж, норматив утга холбогдлын тухай философийн судалгаа хийх ёстойг (Ander, The Sexual Orientation/ Identity Distinction, 2021) зөвлөсөн байдаг.

Ийнхүү түүхэнд ЛГБТК хүмүүсийн бэлгийн чиг баримжааны тухай үзэл баримтлалууд боловсорч ирсэн бөгөөд өдгөө ч философи маргаан, хэлэлцүүлэг өрнөсөн хэвээр байна. Нийгэм дэх энэ асуудалд ялгаатай олон байр суурь байдгийн заримыг нь дурдахдаа хомосексуал харилцааг эсэргүүцдэг болон үүнд эерэг байр суурь бүхий зарим үндэслэгээг танилцуулья:

1. Хомосексуал харилцаа бол байгалийн биш зүйл: Ингэж үздэг хүмүүсийн хувьд бэлэг эрхтэн бол нөхөн үржихүйн үүрэгтэй тул ижил хүйстний харилцааг байгалийн хуулиас гадуурх

⁸ Испанийн Гэгээн Луизын Их сургуулийн философийн дэд профессор, тэрбээр нийгмийн метафизик, жендер, бэлгийн чиг баримжааны асуудлаар судалгаа хийдэг бөгөөд энэхүү сэдвээр хэд хэдэн өгүүлэл нийтлүүлжээ.

зүйл хэмээдэг. Тухайлбал Аквины Фома бэлгийн харилцаа ёс суртахуунтай байх ёстой гэсэн шаардлага тавьдаг. Ингэхдээ тэрээр хетеросексуаль харьцааг онцолж зөвтгөсөн юм. Эрэгтэй хүний үрийн шингэн зөвхөн эмэгтэй хүний үтрээнд ялгарч байж байгалийн нөхөн үржихүй явагддаг тул тухайн төрлийн бэлгийн үйлдэл нөхөн үржихүйд хүргэхгүй байсан ч (тухайлбал үргүйдлийн улмаас боломжгүй бол) энэ төрлийн бэлгийн харьцааг ёс суртахууны хувьд зөвтгөн ойлгож болно хэмээн тэрээр үзсэн байдаг.

Хүлээн зөвшөөрч буй үндэслэгээ:

Хомосексуал харилцаа бол ямар нэг өвчин биш харин төрөлхийн буюу биологийн шинжтэй байгалийн зүйл юм. Нөгөөтэйгүүр тэд нийгмийн хариуцлагын өндөр мэдрэмжтэй хүмүүс байдаг. Ижил хүйстэн хүмүүс хүүхэд төрүүлэх гэхээс илүүтэй элэг бүтэн гэр бүлийн хүрээнд хүүхдүүдийг асран халамжилж, хайрлан энэрэхийг чухалчилдаг. Орчин үед ижил хүйстэн гэр бүлүүд хүүхэд үрчилэн өсгөж байгаа тохиолдлууд олширсон бөгөөд тухайлбал Өмнөд Калифорнийн Их Сургуулийн социологичидын хийсэн шинэ судалгаагаар лесбиян эсвэл гей эцэг эхтэй хүүхдүүд нийгмийн амьдралын олон янз байдлыг илүү сайн ойлгодог, жендэрийн хэвшмэл ойлголтод бага баригддаг, ижил хүйстнүүдийн үйл ажиллагааг өөрсдөө судлах магадлал өндөр байдаг гэжээ.

2. Хувьсал биднийг үр удамаа үлдээхийг шаарддаг: Энэ үндэслэгээ ёсоор ижил хүйстний харилцаанд нөхөн үржихүй гэдэг бололцоогүй. Ийм хосын харилцаа үр удам үлдээж чадахгүй тул хувьслын, байгалийн хуулиас гадуурх зүйл мөн. Тухайлбал гэрлэлт бол тодорхойлолтоороо нөхөн үйлдвэрлэл юм, тэгвэл эрэгтэй юм уу, эмэгтэй хомосексуал харилцаатай хүмүүс нөхөн үйлдвэрлэл явуулж чадахгүй, тэгэхээр тэдний гэрлэлт бол жинхэнэ гэрлэлт биш (Вольф, 2021, хууд. 234).

Хүлээн зөвшөөрч буй үндэслэгээ: Ижил хүйстний харилцаа бол үр удам үлдээдэггүй

бэлгийн харьцааны цорын ганц хэлбэр биш юм. Бас хүн бүхний мэдэж буйгаар хүүхэд төрүүлж чадахгүй, хүүхэд төрүүлэхийг хүсдэггүй, хэзээ ч гаргаж байгаагүй хүмүүсийн гэрлэлтийг төр баталсаар байдаг (Вольф, 2021, хууд. 234).

3. Хомосексуал харилцаа эрүүл мэндийн асуудал дагуулдаг: Ижил хүйстэнтэйгээ бэлгийн хавьталд орох нь садар самуун, бэлгийн замын халдварт өвчнийг тараах эрсдэлтэй гэдгийг тоон судалгаагаар Монтоя хэмээх эрдэмтэн харуулахыг оролдсон байна (Montoya, 2008). Мөн сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлдөг тухай сөрөг байр суурь бий. Жишээ нь, теологийн профессор Роберт Э.Ж. Гэгнон лесбиян харилцааны талаарх судалгаанууд ижил хүйстэн эмэгтэйчүүд бэлгийн харьцааны хувьд хэмжигдэхүйц хохирол амсдаг, хетеросексуаль эмэгтэйчүүд, гомосексуаль эрэгтэйчүүдтэй харьцуулахад тэдний сэтгэцийн асуудал харьцангуй өндөр хувьтай байдаг (A.J.Gagnon, 2009) гэсэн дүгнэлт хийсэн аж.

Хүлээн зөвшөөрч буй үндэслэгээ:

Ижил хүйстэн хүмүүст эрүүл мэндийн асуудал тулгардаг хэдий ч тэр нь ижил хүйстэн байх гэдэгтэй шууд холбоогүй. Бэлгийн замын халдварт өвчнөөр өвчилсөн ижил хүйстнүүдийн талаарх статистикийн тоон мэдээллүүд нь тэднийг үндэслэлгүй ялгаварлан гадуурхахаас өөр зүйл биш бөгөөд ижил хүйстнүүдийн эсрэг өрөөсгөл ойлголтыг нийгэмд бий болгох сөрөг үр дагавартай аж. Статистикийн тоон мэдээлэл бол биологийн төрөлх шинжийг дүгнэх гол үзүүлэлт, үндсэн шалгуур биш. Харин ч тэднийг цөөнх хэмээн ялгаварлахтай адил зүйл болох юм. Ижил хүйстэн байх нь сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлдөг тухай санааг хомосексуал харилцаатай хүмүүсийн сэтгэцийн өвчлөл хетеросексуал хүмүүсийнхтэй харьцуулахад илүү өндөр байдаг гэдгийг хангалттай үндэслэж өгсөн статистикийн мэдээллүүд байхгүй

байна. Тийм болохоор ижил хүйстнүүдийг сэтгэцийн өвчтэй гэж буруутгах нь үндэслэлгүй ялгаварлан гадуурхалт юм гэсэн тайлбараар няцаах боломжтой. Харин хомосексуалууд амиа хорлох оролдлого хийх байдлыг нийгмийн гадуурхалт болон үзэн ядалттай холбож үзэх хэрэгтэй гэдгийг зарим судлаач анхааруулсан байна (Martin Ploderl, 2013).

4. Хомосексуал харилцааг зөвшөөрвөл энэ нь олон хүнд нөлөөлөх болно.

Ижил хүйстнүүдийг соёлын хувьд хүлээн зөвшөөрч, дэмжих нь залуучуудад илүү их нөлөөлнө гэсэн болгоомжлол байдаг. Тухайлбал Алекс Д. Монтоягийн үзснээр бэлгийн харилцааг либералчлах, үр хөндөхийг хориглохгүй байх, порнографыг хүлээн зөвшөөрөх, ижил хүйстнүүдийг дэмжих зэрэг нь америкчүүдийн ёс суртахуунд эрсдэл учруулжээ (Montoya, 2008). Ингэхдээ тэрээр олон сая үр хөндөлт хийж буй, сая сая хүүхэд гэрлэлтээс гадуур төрсөн, холимог гэр бүлийн үе хойчис бий болсон, гэр бүл, гэрлэлтийн үнэ цэнэ деструкцид орсон, сургуулийн хүүхдүүдийн ёс суртахууны байдал доройтсон болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ижил хүйстнүүдийг урьд өмнө байгаагүйгээр өргөн хүрээнд сурталчлах болсон зэргийг эмзэглэн тоочиж, эдгээр нь нийгэм дэх эмх цэгцгүй, дэг журамгүй байдлыг улам бүр нэмэгдүүлж байна гэжээ.

Хүлээн зөвшөөрч буй үндэслэгээ:

Ижил хүйсийн асуудлыг хүлээн зөвшөөрсөн үндэслэгээг судлаач Рэнди Элкорн дараах байдлаар тодорхойлсон нь сонирхол татахуйц байна. Үүнд: а.) Ижил хүйстэн байх бол төрөлх чанар бөгөөд өвчин ч биш, сонголт ч биш, өөрөөр хэлбэл чөлөөт хүслээр үйлдэх, сэтгэлзүйн эмчилгээ, шашны туршлагаар өөрчлөх боломжтой тийм зүйл биш; б.) Ижил хүйстний харьцаанд орох нь хетеросексийн адил байгалийн зүйл боловч энэ нь харьцангуй бага тохиолддог.

Энэ нь буруугаар чиглүүлсэн юм уу эсвэл хомофобик үзлээс үүдсэн нийгмийн гутаан доромжлолд өртдөгөөс бусдаар тийм ч хүсэшгүй нөхцөл биш юм; в.) Ижил хүйстнүүд бол хар арьстнууд, Чиканосуудын адил хууль ёсны цөөнх мөн. Ижил хүйстний эрх нь эмэгтэйчүүдийн эрхтэй адил хүчин төгөлдөр байна; г.) Өрнөдийн соёлын хөгжилд ижил хүйстнүүд чухал хувь нэмэр оруулсан байдаг. (Ижил хүйстнүүдийн уран зохиол ихэвчлэн ижил хүйстэн зураачид, хөгжимчид, яруу найрагчид, төрийн зүтгэлтнүүд гэх мэт алдартай хүмүүсийн бүтээлийн ишлэлээр дүүрэн байдаг); д.) Ижил хүйстнүүд өөрсдийн нөхцөл байдлаа илэн далангүй хүлээн зөвшөөрч “*өрөөнөөсөө гарч ирж*”, хүссэн амьдралын хэв маягаар амьдрах, ижил хүйстэнтэй харилцах харилцааг эрэлхийлдгээсээ ичих ёсгүй (L.Holland, 2008) хэмээсэн ажээ.

5. Хомосексуал харилцаа нь шашны сургаалын эсрэг үйлдэл юм.

Тухайлбал, христийн шашны ёсоор ижил хүйстний бэлгийн харилцаа бол Эзэн Бурхны хүслээс гадуур зүйл буюу нүгэлт зүйл ажээ. Басениз гэр бүлийн талаарх “Гэрлэлт ба хомосексуаль байдал: Библийг ойлгохуй” өгүүлэлд хомосексуал харилцааны асуудалд сөрөг байр суурь баримталж буйгаа илэрхийлж бичихдээ: Эзэн Бурхан, өөрийн бүтээн бий болгох ажилд таван зорилго тавьсан. Эдгээр нь: 1. Нөхөн үржихүй, 2. Нэг эрэгтэй, нэг эмэгтэйн нэгдэл, 3. Эмэгтэй хүн эр хүнийг бүрэн бүтэн болгодог гол зүйл 4. Христ болон сүм хийдийн харилцаа 5. Эхнэр, нөхрийн гол үүргийн тухай юм хэмээн дурдсан (A.Busenitz, 2008). Энэ нь хетеросекс харилцааг анхнаасаа Библи зөвтгөсөн гэснийг харуулж байгаа хэрэг мөн бөгөөд тэрээр, Нью Йорк Таймс 2003 онд АНУ гэрлэлтийн дараахь нийгэм болон хувирлаа хэмээснийг эшлээд, ижил хүйсийн асуудалд шүүмжлэлтэй ханджээ. Тэрээр энэ харилцааг үгүйсгэн... гей эсвэл лесбиян гэрлэлт ижил хүйстнүүдийн харилцааг дагалддаг

сөрөг хандлагыг арилгахгүй... Гэрлэлт бол чөлөөлөгдөлтийн зам биш... Бид гэрлэлтийн жинхэнэ хувилбаруудыг бий болгох, нийгмийн гэр бүлийн тухай үзлийг эрс өөрчлөх зорилгод анхаарлаа хандуулах ёстой л гэснийг эшлэн уламжлалт гэр бүлийн бүтцийг хамгаалан ширүүн өнгө аястайгаар бичсэн байдаг. Мөн ийм байр суурийг илэрхийлж МакАртур, хетеросексуал гэрлэлтээс гадуур аливаа бэлгийн харьцаанд орохыг Бичээс тодорхой хориглодог нь эргэлзээгүй (MacArthur, 2008) хэмээсэн нь хомосекс харилцааг шүүмжлэхдээ шашны байр суурь, уламжлал гэрлэлтийн онцлогийг голлох үндэслэлээ болгож буй нь харагдаж байна.

Хүлээн зөвшөөрч буй үндэслэгээ: Боиз коллежийн⁹ Библи судлалын профессор Денни Бирк, “Гомосексуаль бэлгийн чиг баримжаа нүгэл гэж үү?” өгүүлэлдээ: “ижил хүйстний сэтгэл татагдах байдлыг мэдэрдэг хүмүүсийг хайрлах, өрөвдөх сэтгэлийг маань бэхжүүлэх ёстой. Олонхын хувьд ижил хүйстний тэрхүү байдал нь амьд ахуйгаа мэдэрсэн зүйл юм. Тэдний бие биедээ татагдах байдлыг эмгэг гэж хэлж болохгүй. Эдгээр хүн бүгд сүмээс гадуур байх ёстой гэж бодох нь гэнэн хэрэг юм. Үгүй ээ, тэд бидний дунд байна. Тэд бол бид мөн. Тэд баптизм хүртэж, бидэнтэй хамт Эзэний ширээнд сууж байна. Тэд бэлгийн амьдралынхаа талаар Библид бичсэн зүйлд итгэдэг ч тэдний тэмцэл хэцүү” гэсэн байдаг. Тэгэхээр энэ үзлийг хомосексуал

хүмүүсийн харилцааг шууд дэмжиж буй хүчтэй аргумент гэхээс илүүтэй тэд ч бас Бурханы хайрыг мэдэрч, авралыг хүртэнэ гэсэн энэрэнгүй сэтгэлийн илэрхийлэл гэж ойлгож болох юм¹⁰.

Буддизмд хүний оюун санааны мөн чанар гэмгүй, ариун тул бүгд гэгээрэх бололцоотой гэж үздэг бөгөөд аливаа үйлдлийн цаад сэдэл, зорилгыг нь анхаарахыг чухалчилдаг. Ийнхүү хувь хүний бэлгийн харилцааны зорилго нь өгөх, хайраа илэрхийлэх, халамжлах бол тухайн үйл зөв хэмээн үзэх учиртай энэ утгаар буддын шашныг бэлгийн цөөнхийг ялгаварладаггүй, эл асуудалд хүлээцтэй ханддаг гэсэн тайлбарыг зарим судлаач (Cheng, 2018) хийсэн байна¹¹.

6. Хомосексуал хүмүүс энгийн гэр бүлээс тусдаа байх ёстой. Ижил хүйстэн хүмүүс энгийн хүмүүсээс ялгаатай тул өөрсдийн гэсэн нийтлэгтэйгээ буюу тусдаа байх ёстой. Тэр ч атугай дээрх шалтгаануудын улмаас тэд гэрлэх, энгийн хүмүүсийн хүрээлэлд байх ёсгүй. Бүр цаашилбал хомосексуал харилцаатай хүмүүс нь гэр бүлийн бүтцийг эвддэг, мөн жендэрийн үүргийг тодорхойгүй болгодог гэж үзэх явдал бий. Нийгмийн тогтвортой байдлыг хангахын тулд үүнийг зөвшөөрөхгүй байхыг санал болгодог.

Хүлээн зөвшөөрч буй үндэслэгээ: Бүх хүн эр, эм хосын гэр бүлд төрж, өсч өндийдөг. Иймээс хомосексуал хүмүүс бас гэр бүлийн гишүүн байх бүрэн эрхтэй. Энэ

⁹ АНУ-ын Кентаки дахь Христос шашины сургалт явуулдаг, Өмнөдийн коллеж, сургуулиудын холбоо, АНУ, Канадын теологийн сургуулиудын холбооны гишүүнчлэлтэй коллеж.

¹⁰ Жич нэг зүйлийг дурдахад христийн католик шашины тэргүүн Ромын Пап лам Францис: “Бид бүгдээрээ Эзэн бурханы хүүхдүүд бөгөөд Бурхан биднийг байгаагаар нь, хүн нэг бүр эрхэм чанарынхаа төлөө тэмцэж байдаг хүч чадлыг маань хайрлаж байдаг. Ижил хүйстэн байх нь гэмт хэрэг биш. Энэ бол гэмт хэрэг биш” гэж мэдэгдсэн аж. Энэ бол орчин үеийн нийгэм дэх хүмүүнлэг, хүний эрхийг дээдэлсэн үзэл хандлагын нэг илрэл мөн билээ. <https://www.usccb.org/news/2023/pope-clarifies-remarks-about-homosexuality-and-sin>

¹¹ Гэхдээ буддизмын хувьд шашины хувраг хүний даган баримтлах ёстой дэг жаягт аливаа төрлийн бэлгийн зан үйлийг цээрлэдэг ажээ. Энэхүү өгүүлэлд тус шашины талаарх зарим судлаачийн байр суурийг нь онцолсон болно. Мөн Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам нэгэнтээ “бэлгийн чиг баримжаа харгалзахгүй, бүх хүний эрхийг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрөхийг дэмжинэ” гэдгээ илэрхийлсэн бөгөөд ижил хүйстнүүдийн гэрлэлтийг тухайн хүний сонгосон шашины үнэт зүйлстэй харилцахгүй бол хүлээн зөвшөөрнө гэж хэлсэн нь анхаарууштай ажээ. (2014 оны 3-р сарын 10) <https://www.youtube.com/watch?v=pJVvVsr8E2M>

бол бүх иргэнийг гэрлэлтийн харилцаанд зүгээр л багтаагч гэсэн үндэслэл (Вольф, 2021, хууд. 233) бөгөөд хомосексуал хүмүүсийг нийгмээс тусгаарлан зааглах ёсгүйг онцолсон байдаг.

Эдгээр нь ёс зүй, хүний эрх, философийн үүднээс ижил хүйстний бэлгийн чиг баримжааг зөвшөөрөх болон эсэргүүцэх үндэслэгээний нийтлэг байдаг хувилбарууд юм. Зарим философич хомосексийн харилцаа хүний бэлгийн амьдралын жам ёсны бөгөөд хэвийн зүйл учир өөр өөр соёл, иргэншил энэ талаар ялгаатай үзэл бодолтой байдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэж маргадаг. Тэд нийгэм соёлын олон янз байдал, тэр дундаа бэлгийн чиг баримжаа дахь олон янз байдлыг хүндэтгэж, тэмдэглэх ёстой гэж үздэг байна. Өнөөдөр ч бас энэ талаархи нийгмийн хэлэлцүүлэг үргэлжилж байгаа бөгөөд шинэ шинэ үндэслэл гарч ирсээр байна. Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийн үзэл санааг сахин баримталж буй өнөө цаг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид ЛГБТК хүмүүсийг ялгаварлан гадуурхдаггүй. Харин олон нийтийн санаа бодол, байр суурь ихээхэн ялгаатай байдаг нь эл асуудлыг олон талаас авч үзэх, онолын талаас тайлбарлах хэрэгцээ шаардлагатайг энэ өгүүлэлээр харуулахыг эрмэлзсэн болно.

Ном зүй

1. Ариун Библи. (2004).
2. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн тухай хэрхэн бичих вэ? Хэвлэл мэдээллийн ажилтнуудын гарын авлага. (2019).
3. Вольф, Р. П. (2021). Философийн тухай. Улаанбаатар: Мөнхийн Үсэг.
4. Гидденс, А. (2006). Социологи. Улаанбаатар.
5. Иргэний нийгмийн хууль эрх зүй, нийгмийн орчны оролцоонд суурилсан үнэлгээ, шинжилгээ. НҮБ. (2014). Улаанбаатар.
6. Жогжакартын зарчмууд. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн чиг баримжаа илэрхийлэлд олон улсын хүний эрх, эрх зүйг хэрэглэх зарчмууд
7. П.Золжаргал, Б. Ц. (2020). Монгол дахь бэлгийн цөөнхийн олон нийтийн хандлага, эрхийн хэрэгжилт. Гэр бүлийн ёс зүйн асуудал, 289.
8. Нийгэм-улс төрийн философийн орчин үеийн онолууд. (2003). Тотопресс.
9. Andler, M. (2022). Queer and Straight. In *The Routledge Handbook of Philosophy of Sex and Sexuality* (p. 14). Routledge.
10. Andler, M. (2021). The Sexual orientation/ Identity Distinction. *Hypatia*, 259-275.
11. Andreas De Block, P. A. (2007). Darwinizing sexual ambivalence: a new evolutionary hypothesis of male homosexuality. *Philosophical Psychology*, 59-76.
12. Banovic, D. (2020). Philosophical and Legal Foundations for LGBT Rights.
13. Bauer, D. (2006). Homosexuality within the Context of Social Institutionalization and Moral Sense. *Ethical Perspective: Journal of the European Ethics Network*, 63-91.
14. A. Busenitz, I. (2008). Marriage and homosexuality: toward a biblical understanding. *The Master's Seminary Journal*, 203.
15. K. Cahn, S. (1992). Sexual Histories, Sexual Politics. *Feminist Studies*, 629-647.
16. Cheng, F. K. (2018). Being different with Dignity: Buddhist Inclusiveness of Homosexuality. *Social Sciences*.
17. Denny Burk. (2015) Is homosexual orientation sinful?
18. Gabezon. (1992). Buddhism, Sexuality and Gender.
19. A.J. Gagnon, R. (2009). Why Homosexual Behavior Is More like Consensual Incest and Polyamory than Race or Gender.
20. Glass, G. F. (2017). Doctor Anonymous: Creating Contexts for Homosexuality as mental Illness. *J Med Humanit*.
21. A. Grisanti, M. (2008). Cultural and Media myths about Homosexuality. *The Master's Seminary Journal*, 175-202.

22. L.Holland, R. (2008). Christian Parenting and Homosexuality. The Master's Seminary Journal, 217-231.
23. Kirsten Leng, K. S. (2020). Histories of sexology today: Reimagining the boundaries of scientia sexualis. History of Human Sciences, 1-7.
24. Lang, B. (2021). Normal enough? Krafft-Ebing, Freud, and homosexuality. History of the Human Sciences, 90-112.
25. MacArthur, J. (2008). God's word on homosexuality: The Truth about sin and the reality of forgiveness. The Master's Seminary Journal, 153-174.
26. Martin Ploderl, (2013). Suicide Risk and Sexual Orientation: A Critical Review. Volume 42, 715-727
27. Montoya, A. D. (2008). The Church's Response to Homosexuality. The master's Seminary Journal, 233-248.
28. Peter Cryle, E. S. (2017). Normality: A Critical Genealogy. The University of Chicago Press.
29. Schwartz, J. (2008). Plato's Validation of Heterosexuality in Symposium. Comparative Humanities Review. Vol 2., 20-25.
30. Tuana, N., & Laurie Shrage. (2005). Sexuality. In The Oxford Handbook of Practical Ethics. Oxford University Press.
31. A.Yarhouse, M. (2004). Homosexuality, Ethics and Identity Synthesis. Christian Bioethics, 239-257.

Цахим эх сурвалж:

- Retrieved from <http://robgagnon.net/articles/homosexIncestPolyAnalogy.pdf>
- <https://pep-web.org/browse/document/zbk.051.0423a?page=P0423> (Cheng, 2018)
- <https://www.pewresearch.org/global/2020/06/25/global-divide-on-homosexuality-persists/>
- <https://www.youtube.com/watch?v=pJVvVSr8E2M>
- <https://www.usccb.org/news/2023/pope-clarifies-remarks-about-homosexuality-and-sin>

Abstract

This article discusses the significance of the LGBTQ issue, which encompasses human rights, ethics, society, and existence. Being a sexual minority, this group has historically faced challenges, and their perception throughout history has been influenced by religious and some other perspectives. It's important to note that within the scope of this evaluation, we neither seek to endorse nor criticize any specific standpoint.

However, it is true that in today's Mongolian society, which upholds the principles of a humane civil democratic society, there is greater openness to the topic of sexual orientation. Nevertheless, this article aims to emphasize the necessity of considering this issue from multiple perspectives and providing a theoretical explanation, as there exist diverse opinions within the public discourse.